



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2013 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 4/69

Амардалай

Газар эзэмших эрх дуусгавар болгох  
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр (Цагаан эрэг)-д байршилтай иргэн Жамбалдорж овогтой Хатанбаатар (ЗЕ79052416)-ын өвөлжөө, хаваржааны зориулалттай 5000 м.кв (0.5 га) газраа ашиглахгүй тул 4811000231 нэгж талбарын дугаартай газар эзэмших эрхийг дуусгавар болгож нийтийн эдэлбэрийн газар болгосугай.

2. Дээрх иргэний газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгож, нэгж талбарын талаарх өөрчлөлтийг Газрын мэдээллийн цахим системд бүртгэхийг Газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 05 тоот захирамжийн Ж.Хатанбаатар-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

